



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/622

Булган сум

Сургалт явуулах тухай

Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, Монгол улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Булган аймагт төлөөлөн 2023 онд хэрэгжүүлэх гэрээний 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн аврах бүлэг цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдийн нэгдсэн сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 13-аас 09 дүгээр сарын 23-ний хооронд Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургалтын төвд төвлөрүүлэн зохион байгуулсугай.

2. Цэргийн албыг дүйцүүлэн хааж буй иргэдтэй сургалт зохион байгуулах бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, зарцуулах хөрөнгийн төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Сургалтад шаардагдах 8,669,000 (найман сая зургаан зуун жаран есөн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөнөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

4. Цэргийн албыг дүйцүүлэн хааж буй иргэдтэй явуулах сургалтыг хугацаанд нь зохион байгуулж, дүнг 10 дугаар сарын 05-ны дотор илтгэхийг Цэргийн штаб (д/х Ч.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны
08 сарын 21-ны өдрийн 1/62 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



**ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ СУРГАЛТЫГ
ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛАХ БҮРЭЛДЭХҮҮН**

Сургалтын удирдагч	д/х Ч.Энхбаяр	- ЦШ-ын дарга
Сургалтын төвийн захирал	х/ч Б.Намнансүрэн	- ЦШ-ын ОНХС-ын офицер
Багш нар	х/ч Ц.Цэрэнтогтох	- ЦШ-ын Дайчилгааний офицер
	х/ч Г.Эрдэнэхүү	- 186-р ангийн офицер
	д/ч Э.Мөнх-Эрдэнэ	- Онцгой байдлын газар
Жагсаалын дарга	а/ч Н.Болдбаатар	- ЗХ-ний 186-р анги
Тогооч	Д. Батжаргал	- ЗХ-ний 186-р анги

Аймгийн Засаг даргын 2023 оны
02 сарын 21 ны өдрийн 162 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



СУРГАЛТАНД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

1	Зардлын чиглэл	Хөрөнгийн хэмжээ	Тайлбар
1	Хоолны үнэ	6,840,000	Цэргийн албан хаагчийн хоногийн хоолны нормоор 18000 төг*38хүн *10 хоног
2	Багш нар, тогоочийн цалин	1,000,000	5 хүн*20000 төг*10 хоног
3	Бичиг хэргийн зардал	101,000	Дэвтэр, бал 1хүн 2000 төг Бичгийн цаас 1ш 25.000
4	Шатахуун	728,000	150л А-92 бензин 2520төг 100л Түлш 3500
5	Бусад	150,000	Шүдний 00, саван ,00 цаас
	Бүгд		8,669,000